

БАТЛАВ  
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Д.ОТГОНБАЯР

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АВТО  
ЗАМЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАМ ГҮҮРИЙН АЖИЛ, ӨРГӨТГӨЛ, ЗАСВАРЫН  
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ АЖЛЫН ДААЛГАВАР  
/ Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг/

2024 оны 11 дүгээр ... сарын 15 өдөр

Дугаар УАГ-АД/2024-37

Улаанбаатар хот

**Ажлын зорилго:** Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2024 оны эхний хагас жилд санхүүжүүлсэн авто замын ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийх аудитын хүрээнд замын сангийн хөрөнгөөр Сонгинохайрхан дүүрэг, Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэгт хэрэгжүүлж буй замын байгууламж, авто замын их засварын ажлын зураг төсөв, төсөвт өртөг болон ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, норм дүрэм, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

**Аудит гүйцэтгэх хугацаа:**

Эхлэх хугацаа: 2024 оны 11 дүгээр сарын 1 өдөр

Дуусах хугацаа: 2024 оны 12 дүгээр сарын 25 өдөр

**Байршил:** Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг

**НЭГ. ҮНДЭСЛЭЛ**

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 01/4918 дугаар албан бичиг, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд тус хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу аудитыг хийнэ. Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 15.5-д заасны дагуу мэргэжлийн тусгай мэдлэг, ур чадвар бүхий этгээдийг шинжээчээр аудитад татан оролцуулна.

**ХОЁР. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

Шинжээч нь Нийслэлийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн, хүснэгтэд заасан авто зам, замын байгууламж, их засварын ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргах ажлыг хэрэгжүүлнэ.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг /төгрөг/
			эхлэх	дуусах	
1	Нийслэлийн Засаг дарга	Орбитын авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Сонгинохайрхан дүүрэг)	2024	2024	2,890,000,000.00
2	Нийслэлийн Засаг дарга	Хотын гол болон туслах гудамж замуудын арчлалт, засварын ажил(Сонгинохайрхан дүүрэг-1)	2024	2024	1,700,000,000.00
3	Нийслэлийн Засаг дарга	Хотын гол болон туслах гудамж замуудын арчлалт, засварын ажил(Сонгинохайрхан дүүрэг-2)	2024	2024	1,700,000,000.00
4	Нийслэлийн Засаг дарга	Хотын гол болон туслах гудамж замуудын арчлалт, засварын ажил (Сүхбаатар дүүрэг-1)	2024	2024	1,000,000,000.00
5	Нийслэлийн Засаг дарга	Хотын гол болон туслах гудамж замуудын арчлалт, засварын ажил (Сүхбаатар дүүрэг-2)	2024	2024	1,000,000,000.00

6	Нийслэлийн Засаг дарга	Авто зам, гүүрийн ажил /Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 15, 16 дугаар хороо/	2020	2024	3,970,178,697.00
7	Нийслэлийн Засаг дарга	Бага тойруугийн авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлт (Чингэлтэй дүүрэг, Сүхбаатар дүүрэг)	2024	2024	3,700,000,000.00
8	Нийслэлийн Засаг дарга	Хувьсгалчдын гудамжны авто замын засвар шинэчлэлт (Тасганы овооны уулзвараас Зурагтын эцэс хүртэл)	2024	2024	3,800,500,000.00
9	Нийслэлийн Засаг дарга	Хотын гол болон туслах гудамж замуудын арчлалт, засварын ажил (Чингэлтэй дүүрэг-2)	2024	2024	1,400,000,000.00
10	Нийслэлийн Засаг дарга	Дэнжийн 1000-ын Цагаан байрны уулзвараас Хүчит шонхор захын уулзвар хүртэлх туслах замын өргөтгөл /Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг/	2024	2024	8,377,584,557.00
		ДҮН			29,538,263,254.00

### ГУРАВ.ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь дараах ажил үүргийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

Д/д	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан эсэхэд шинжээчийн дүгнэлт гаргах;	Төсвийн тухай хууль, Авто замын тухай хуулийн 10, 16 дугаар зүйл, "Авто зам төсөвлөх" ЗЗБНБД 22-004-2016 "Авто зам, замын байгууламжийн ажлын жишиг техникийн шаардлага", холбогдох бусад хууль, журам, стандарт	Нийслэлийн замын сангийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан зарим авто зам, замын байгууламж, их засварын ажлын зураг төслийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлагад нийцэж, үр нөлөө, үр дүн бий болсон эсэхэд дүгнэлт гаргахад оршино.	✓ Тооцоо судалгаа, шаардлагад үндэслэн төлөвлөсөн байх; ✓ Холбогдох байгууллагуудаас техникийн нөхцөл, бусад зөвшөөрлийг авсан байх; ✓ Зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан байх; ✓ Зурагт магадлал хийж, дүгнэлт гаргасан байх
2	Авто зам, замын байгууламжийн ажлын төсвийг батлагдсан зургийг үндэслэн холбогдох хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиосон эсэхэд дүгнэлт гаргах;	Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 168 дугаар тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам", холбогдох бусад хууль, журам, стандарт	хэмнэлттэй байхаар төлөвлөж, ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлагад нийцэж, үр нөлөө, үр дүн бий болсон эсэхэд дүгнэлт гаргахад оршино.	✓ Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага гүйцэтгэсэн байх; ✓ Хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв, бодитой зохиосон байх; ✓ Төсөвт магадлал хийж, дүгнэлт гаргасан байх;
3	Замын байгууламжийн ажил нь магадлал хийгдэж, баталгаажсан зураг	Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйл, батлагдсан зураг, төсөл, автозамын норм	хэмнэлттэй байхаар төлөвлөж, ажлын гүйцэтгэл нь Монгол Улсын хууль тогтоомж, барилга, байгууламжийн норм, дүрэм, стандартын шаардлагад нийцэж, үр нөлөө, үр дүн бий болсон эсэхэд дүгнэлт гаргахад оршино.	✓ Хөрсний бодит байдал инженер геологийн дүгнэлттэй нийцсэн байх;

	төсөл, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу гүйцэтгэгдсэн эсэхэд дүгнэлт гаргах;	нормативын баримт бичиг, холбогдох бусад хууль, журам, стандарт		<ul style="list-style-type: none"> <li>✓ Суурь, хучилтын ажил, хөвөөний болон бусад байгууламжууд, авто замын тоноглол, тохижилт, тэмдэг, тэмдэглэгээний ажил тус бүрийг зураг, төсөв, норм, стандартын дагуу гүйцэтгэсэн байх;</li> <li>✓ Автозам, замын байгууламжийн ажилд ашигласан материал нь чанарын шаардлага хангасан байх;</li> </ul>
4	Авто зам, замын байгууламжийн үе шатны ажлуудад хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байдал, өгсөн зааварчилгаа, түүнийг хэрэгжүүлж ажилласан байдлыг нягтлан шалгаж, дүгнэлт гаргах;	Авто замын тухай хуулийн 21 дүгээр зүйл, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам, холбогдох бусад хууль, журам, стандарт		<ul style="list-style-type: none"> <li>✓ Авто зам, замын байгууламжийн ажилд хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагатай захиалагч, зохиогчийн хяналтын, зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан байх,</li> <li>✓ Гүйцэтгэгчийн дотоод хяналтыг өдөр тутам гүйцэтгэж, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгасан байх;</li> <li>✓ Эрх бүхий байгууллагаас барилга байгууламжийн ажилд үе шатны болон өдөр тутмын хяналт гүйцэтгэсэн байх;</li> <li>✓ Ил, далд ажлын актыг үнэн зөв, бүрэн баталгаажуулсан байх,</li> <li>✓ Бүх төрлийн хяналтын зардал, норм нормативын санг зориулалтын дагуу зарцуулсан байх;</li> <li>✓ Бүх төрлийн төлбөр хураамжийг улс, орон нутгийн төсөвт зүй ёсоор төвлөрүүлсэн байх</li> </ul>
5	Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комисс ажилласан байдал, тэдгээрээс өгсөн үүрэг даалгавар хэрэгжсэн эсэхэд дүгнэлт гаргах;	Авто замын тухай хуулийн 28 дугаар зүйл, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49-р тушаалаар баталсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам", холбогдох бусад хууль, журам, стандарт		<ul style="list-style-type: none"> <li>✓ Авто зам, гүүрийг ашиглалтад оруулах техникийн болон улсын комиссыг хууль, журмын дагуу томилж ажиллуулсан байх;</li> <li>✓ Комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжсэн байх;</li> <li>✓ Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, барилга</li> </ul>

				байгууламжийн гүйцэтгэлийн болон хяналтын бүх баримт материалуудыг архивын нэгж болгосон байх, ✓ Авто зам, замын байгууламжийг данс бүртгэлд тусгасан байх;
6	Шинжээчийн дүгнэлт гаргах ажлын явцад орц, материалын тоо хэмжээ, нэр төрөл, чанар, агууламж зэргийг хянаж, батлагдсан төсөв болон бодит гүйцэтгэл, олгосон санхүүжилтийн хооронд зөрүү илэрсэн тохиолдолд гүйцэтгэлийн өртөгт үзүүлэх нөлөөллийг тогтоож, төсөвт гарсан хэмнэлт, хэтрэлтийг тоо хэмжээ болон үнийн дүнгээр гаргах.	"Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм" ЗЗБНБД 81-013-2019, Автозам, замын байгууламжийн ажлын төсөв, холбогдох бусад хууль, журам, стандарт		✓ Авто зам, замын байгууламжийн орц, материалын тоо хэмжээ, нэр төрөл, чанарын гүйцэтгэл нь батлагдсан төсөвтэй дүйцэж байх; ✓ Магадалшгүй ажил, захиалагчийн хяналтын зардлын хэтрэлт, хэмнэлтийг тооцож, бодит гүйцэтгэлээр санхүүжүүлсэн байх;
Нэмэлтээр гүйцэтгэх ажил. /Тухайн ажил үүргийн хүрээнд нэмэлт ажил хийгдэх тохиолдолд гүйцэтгэх ажил үүргийг нэмж оруулна.				
7	-			✓

### ГЭРЭЭТ АЖИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ХЭМЖЭЭ, ФОРМАТ

- Шинжээчийн үе шатны ажлын тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 15-аас багагүй, 35-аас ихгүй хуудас /мөр хоорондын зай "single", үсгийн хэмжээ "arial" 12/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.
- Шинжээчийн дүгнэлт гаргах үндэслэл болгосон холбогдох нотлох баримт, тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль тогтоомж, стандарт норм дүрэм, эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

### **ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН**

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажилбаруудыг төсөл, арга хэмжээ бүрээр, чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, барилга, байгууламжийн зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, норматив, стандартаар тавигдах бусад шаардлагуудтай нийцсэн эсэх, авто зам, замын байгууламжийг техникийн шаардлагын дагуу барьж ашиглалтад оруулсан эсэх, санхүүжилтийг үнэн зөв олгосон эсэхийг хянан үзэж, гарсан үр дүн, үр нөлөөг тусгасан мэргэжлийн дүгнэлт бүхий тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн ажил гүйцэтгэх явцад авто зам, замын байгууламжийн зураг төсөл, их засварын ажлын гүйцэтгэлд илэрсэн алдаа зөрчил, шалтгаан болон үр дагаварт хийсэн дүн шинжилгээ, дүгнэлтээс гадна илэрсэн зөрчлийг арилгах, тулгарсан асуудлыг шийдвэрлэх талаар зөвлөмж, санал боловсруулж, тайланд тусгана.

Шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

## ТАВ. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээч нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хүрээнд хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, магадлал хийх, дүгнэлт гаргах эрх бүхий, төслийн эдийн засгийн үр өгөөж, хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүнг тооцох, үнэлэх талаар мэргэшсэн, авто зам, замын байгууламжийн зураг төсөл, магадлалын чиглэлээр дүгнэлт гаргаж байсан, ажлын гүйцэтгэлд мэргэжлийн түвшинд дүгнэлт гаргаж чадахуйц, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангагдсан, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага туршлагатай иргэн, хуулийн этгээд /түншлэл байж болно/ байна.

Шинжээч нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Шинжээч нь хууль тогтоомжид нийцсэн шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Дараах шаардлагыг хангасан иргэн, хуулийн этгээд, баг /түншлэлээр оролцох/-тэй хамтран ажиллана. Үүнд:

1. Хуулийн этгээд, баг /түншлэлээр оролцох/-ийн хувьд:

- Ахлагч нь авто замын инженер, Монгол Улсын зөвлөх инженер, магистр буюу түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил ажилласан байх;

- Гишүүд нь геодезийн инженер, авто зам, гүүрийн инженер, мэргэшсэн төсөвчин, мэргэшсэн инженер, мэргэжлээрээ 8 ба түүнээс дээш жил ажилласан, судалгаа шинжилгээний болон шинжээчийн ажлын туршлагатай байх.

2. Иргэн оролцох бол:

Геодезийн инженер, авто зам, гүүрийн инженер, мэргэшсэн төсөвчин, мэргэшсэн инженер, мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил ажилласан, судалгаа шинжилгээний болон шинжээчийн ажлын туршлагатай байх.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан шинжээч нь ажил эхлэхийн өмнө болон аудитын явцад /Аудитын баг/-тай уулзалт, ярилцлага хийж, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч болно.

Аудитын багт долоо хоног тутамд ажлын явц, гүйцэтгэлийг танилцуулна. Аудитын явцад үүссэн шийдвэрлэх боломжгүй аливаа асуудлыг тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд мэдэгдэнэ.

### БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, аж ахуйн нэгжийн хувьд улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, боловсролын зэргийн диплом, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, бусад үнэмлэх сертификатын хуулбар;
- Ажлын туршлага тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө, танилцуулга), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);
- Энэхүү ажлын даалгаврын 5-д заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын баталгаажсан хуулбар ирүүлнэ.

## ЗУРГАА. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

### Хянасан:

МЕНЕЖЕР



Н.АНХБАЯР

### Боловсруулсан:

АХЛАХ АУДИТОР



Ж.ЭНХТУЯА